



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/42

Мөрөн сум

“Могойн гол” ХК-ийн нүүрс тээвэрлэлтийн
талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Могойн гол” ХК-ийн олборлон гаргаж буй нүүрсний чанар байдлаас шалтгаалан “Хөвсгөл дулааны станц” ТӨХК болон сумдад нэгдсэн халаалтын үйл ажиллагаа явуулж буй компаниудын үйл ажиллагаа доголдож, иргэд, байгууллагыг стандартад нийцсэн дулааны эрчим хүчээр хангаж чадахгүй байдал үүсэж, айл өрх, аж ахуй нэгж, аймгийн Шуурхай штабын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаас гарсан хүсэлт зэргийг шийдвэрлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр зогсоох тухай” А/07 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2. “Могойн гол” ХК-аас Цэцэрлэг-Мөрөн-Эрдэнэтийн чиглэлд 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл нүүрс худалдах, тээвэрлэхийг зөвшөөрсүгэй.

3. “Могойн гол” ХК-аас нүүрсийг тээвэрлэх, худалдан борлуулахдаа MNS 4598:2020 стандартад заасан жин тонныг баримтлан ачилт хийхийг “Могойн гол” ХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Батхүү)-д үүрэг болгосугай.


4. Нүүрс тээвэрлэлтэд жин тонныг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (А.Алтанцоож), аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал), аймгийн Авто тээврийн төвийн дарга (Ө.Баттулга нарт тус тус даалгасугай.

5. Нүүрс тээвэрлэх, худалдан борлуулахдаа нэг дор олон машин цувж явахгүй байхаар тооцож, тээврийн үйл ажиллагааг Иргэний хууль, Автотээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн тээвэрлэлтийн гэрээг байгуулж ажиллахыг “Могойн гол” ХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Батхүү)-д үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6712010124